

Цаг үеийн асуудлаар иргэд , хөдөлмөрчидтэй уулзалт хийлээ.

Дундговь аймгийн уугуул УИХ-ын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Д.Дамба-Очир, ОБЕГ-ын дэд дарга, Хурандаа Б.Ууганбаяр, сумын удирдлагууд иргэд хөдөлмөрчидтэй уулзалт хийлээ.

Уулзалтын эхэнд Засгийн газрын баримталж буй бодлого шийдвэрийг Д.Дамба-Очир гишүүн, аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, 2018 онд баримтлах бодлогын талаар, ОБЕГ-ын дэд дарга, Хурандаа Б.Ууганбаяр Шүлхий өвчний өнөөгийн нөхцөл байдлын талаар иргэдэд мэдээлэл өглөө. Мөн сумын засаг дарга Б.Доржсүмбэр хүүхдийдийн эрүүл мэнд, иргэдийн хөгжих нөхцөл бололцооны асуудлаар 2018 оны спорт заалны зураг төсвийг хийлгэх хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн 2019 оны төсөвт тусгах талаар аймгийн засаг дарга О. Бар –Эрдэнэ, ЭЗБХ хороон дарга Д.Дамба-Очирт уламжиллаа. Уулзалтаар сургуулийн захирал Б.Оюунтөгс сургуулийн дотуур байр сурагчдын суралцах орчинг илүү сайжруулах талаар асуулт тавьж хариулт авлаа.

Мөн иргэд хөдөө аж ахуй, бэлчээрийн болон сум орон нутгийн талаар тулгамдаж буй асуудал , тэтгэвэр, тэтгэмж ,эрүүл мэндийн чиглэлээр асуулт тавьж холбогдох хариултыг хүлээн авлаа. Мөн уулзалтаар эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим хүмүүст салбарын шагналыг гардуулж өглөө.